



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 3 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 113


Улаанбаатар  
хот

Газрын тос боловсруулах үйлдвэрийн  
талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого, Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 14/06 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн банкны тухай хуулийн 16.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Жилд хоёр сая тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Говийн бүсэд, гурван зуун мянган тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Зүүн бүсэд байгуулах урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардлагатай зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Газрын тос боловсруулах үйлдвэрүүдийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүнг 2015 оны III улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Уул уурхайн сайд Р.Жигжид нарт даалгасугай.



Ч.САЙХАНБИЛЭГ

Д.ЭРДЭНЭБАТ